



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 05 өдөр

Дугаар А/210

Мөрөн сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээ
шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2, 38 дугаар зүйлийн 38.1, 38.2, 38.4, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар эзэмших эрхийн гэрчилгээгээ бусдад шилжүүлэх хүсэлт гаргасан 3 иргэний нийт 0.1339га (1339м²) газрыг хавсралтаар тус тус шилжүүлэн эзэмшүүлсүгэй.


2. Уг захирамжаар газар эзэмшиж байгаа иргэдтэй газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг), Улсын бүртгэлийн хэлтэс (Б.Мөнгөнзул)-т тус тус зөвшөөрсүгэй.

3. Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг)-т үүрэг болгосугай.

4. Аймгийн Засаг даргын захирамжийг эс зөвшөөрвөл захирамжийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор аймгийн Засаг даргад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (М.Алтаншагай)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Захирамж-2023

671:010068

Аймгийн Засаг даргын 2023 оны
05 дугаар сарын 05-ны өдрийн
А/210 дүгээр захирамжийн
хавсралт

ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХИЙН ГЭРЧИЛГЭЭГ БУСДАД ШИЛЖҮҮЛСЭН ИРГЭДИЙН ЖАГСААЛТ

№	Эрх шилжүүлж байгаа иргэний овог, нэр, регистр	Эрх шилжүүлэн авч байгаа иргэний овог, нэр, регистр	Нэгж талбарын дугаар	Газрын зориулалт	Газрын байршил, хаяг	Газрын хэмжээ /м2/	Газар эзэмшүү лэх хугацаа	Хүчингүй болгож буй захирамжийн дугаар	Тайлбар
1	Боржигон овгийн Сэрээнэн Халзанхүү (РЭ49032911)	Мандал овгийн Пүрэв Сэрэнжав (РЭ54030807)	6712014256	Гэр, орон сууцны хашааны газар	8-р баг Ширэндэв-1 104 тоот	551	18	Аймгийн Засаг даргын 2011.07.01-ний өдрийн А/225 дугаар захирамжийн 2 дугаар хавсралтын 4 дэх заалт	Өвлөх эрхээр
2	Омбо овгийн Пүрэвжав Баясгалан (РЭ74102112)	Шарнууд овгийн Гэрэлчулуун Ууганзаяа (РГ91020301)	6712016610	Гэр, орон сууцны хашааны газар	7-р баг Хийморь-3 316-3 тоот	308	24	Аймгийн Засаг даргын 2015.07.15-ны өдрийн А/268 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтын 4 дэх заалт	Газар эзэмших эрх шилжүүлэх гэрээгээр
3	Цогнууд овгийн Батчулуун Батдэлгэр (РЭ92032236)	Хоньчин овгийн Бат-Эрдэнэ Ганбаяр (РЮ99122210)	6712017448	Амины орон сууц	13-р баг Баян-Эрхэт-3 305г тоот	480	25	Аймгийн Засаг даргын 2022.07.18-ны өдрийн А/232 дугаар захирамжийн хавсралтын 8 дахь заалт	Газар эзэмших эрх шилжүүлэх гэрээгээр

Нийт газрын хэмжээ: 1339 м²

-----oOo-----